

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/98/НА/-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцооз Утас: 99028555 цахим хаяг: munhuu8555@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



БУЛГАН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ О.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.15 № 2/95
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

0010 0430

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,815,828	86,954,260
35	БАРАА МАТЕРИАЛ	85,815,828	86,954,260
351	Түүхий эд материал	624,000	624,000
35130	Эм боох материал	624,000	624,000
354	Хангамжийн материал	85,191,828	86,330,260
35410	Бичиг хэргийн материал	2,658,480	2,430,693
35420	Аж ахуйн материал	69,613,750	72,003,630
35440	Түлш, шатах тослох материал	4,702,500	4,216,000
35450	Барилгын засварын материал	425,000	330,000
35460	Хүнсний материал	7,792,098	7,349,937
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	803,022,200	982,692,245
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	803,022,200	982,692,245
392	Биет хөрөнгө	792,422,200	972,092,245
39201	Барилга, байгууламж, орон сууц	768,439,250	968,439,250
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,447,975)	(38,255,296)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,650,999	43,620,978
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,482,982)	(27,784,406)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,847,667	100,816,594
39208	Хуримтлагдсан элэгдэл	(92,953,558)	(79,663,475)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,000,000	2,000,000
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(500,000)
39217	Ном	3,368,800	3,418,600
393	Биет бус хөрөнгө	10,600,000	10,600,000
39301	Програм хангамж	275,000	275,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000)	(275,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,600,000	10,600,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	888,838,028	1,069,646,504
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,972,458
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,972,458
413	Өглөг	-	5,972,458
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	5,972,458
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	888,838,028	1,063,674,046
51	Засгийн газрын хувь оролцоо	888,838,028	1,063,674,046
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,511,552	205,511,552
51101	Өмч: - төрийн	205,511,552	205,511,552
512	Хуримтлагдсан үр дүн	40,882,694	217,620,013
51210	Өмнөх үеийн үр дүн	40,882,694	42,783,994
51220	Тайлант үеийн үр дүн	-	174,836,018
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	642,443,782	640,542,482
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	888,838,028	1,069,646,504

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	435,251,262.00	1,001,024,025.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	202,520,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	202,520,100.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	202,520,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	202,520,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,819,662.00	56,474,125.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,431,600.00	742,029,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,500,000.00	23,035,411.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	23,035,411.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,402,000.00	29,194,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,402,000.00	29,194,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,917,662.00	4,244,614.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14,917,662.00	4,244,614.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	408,332,274.63	826,188,006.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	408,332,274.63	826,188,006.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	393,414,612.63	729,084,222.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,939,534.00	574,176,281.91
210101	Үндсэн цалин	314,939,534.00	574,176,281.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,397,194.00	70,339,087.43
210201	Тэтгэврийн даатгал	39,397,194.00	70,339,087.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,337,500.00	28,989,640.00
210301	Гэрэл, цахилгаан	1,053,000.00	4,116,740.00
210302	Түлш, халаалт	15,284,500.00	23,322,900.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,897,870.00	3,152,500.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	2,402,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	598,000.00	750,000.00
2105	Нормативт зардал	5,125,010.00	22,293,238.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	1,017,627.00
210502	Хоол, хүнс	5,125,010.00	21,275,611.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	1,122,250.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	1,122,250.00
2107	Томиллолт, зочны зардал	550,000.00	00.00
210702	Дотоод албан томиллолт	550,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000.00	1,049,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	576,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	473,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,467,504.63	27,962,225.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	2,487,470.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,167,504.63	25,474,755.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,917,662.00	97,103,783.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,917,662.00	26,205,772.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,917,662.00	4,244,614.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	21,961,158.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	70,898,011.66
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	70,898,011.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	26,918,987.37	174,836,018.49
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	26,918,987.37	174,836,018.49

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	642,423,281.92	33,155,373.59	00.00	881,090,207.51
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,511,552.00	642,423,281.92	33,155,373.59	00.00	881,090,207.51
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	26,918,987.37	00.00	26,918,987.37
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	642,443,781.92	40,882,694.03	00.00	888,838,027.95
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	642,443,781.92	40,882,694.03	00.00	888,838,027.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,901,300.00	00.00	1,901,300.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,511,552.00	642,443,781.92	42,783,994.03	00.00	890,739,327.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,901,300.00	00.00	00.00	-1,901,300.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	174,836,018.49	00.00	174,836,018.49
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	640,542,481.92	217,620,012.52	00.00	1,063,674,046.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	750,952,662.00	798,503,925.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	750,952,662.00	798,503,925.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	701,277,300.00	742,029,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,500,000.00	23,035,411.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	23,035,411.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,257,700.00	29,194,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,257,700.00	29,194,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,917,662.00	4,244,614.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14,917,662.00	4,244,614.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	750,952,662.00	798,503,925.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,952,662.00	798,503,925.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,201,749.91	701,400,141.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	531,335,611.91	568,203,824.03
210101	Үндсэн цалин	494,329,437.91	544,915,827.34
210102	Нэмэгдэл	24,072,414.00	22,371,370.69
210104	Урамшуулал	12,933,760.00	916,626.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,744,683.00	70,339,087.31
210201	Тэтгэврийн даатгал	69,744,683.00	64,740,187.31
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,399,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,119,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	280,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,799,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,603,257.00	28,506,140.00
210301	Гэрэл, цахилгаан	4,049,357.00	4,116,740.00
210302	Түлш, халаалт	25,553,900.00	22,839,400.00

210303	Цэвэр, бохир ус	00.00	1,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,702,835.00	4,183,900.00
210401	Бичиг хэрэг	00.00	627,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,721,605.00	2,402,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	981,230.00	750,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	49,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	226,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	128,500.00
2105	Нормативт зардал	41,892,500.00	24,731,427.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,512,500.00	1,182,627.00
210502	Хоол, хүнс	37,397,300.00	22,141,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	982,700.00	1,406,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,549,030.00	281,600.00
210604	Урсгал засвар	5,549,030.00	281,600.00
2107	Томилолт, зочны зардал	550,000.00	
210702	Дотоод албан томилолт	550,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000.00	1,049,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	576,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	473,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,623,833.00	4,105,163.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,623,833.00	4,105,163.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,750,912.09	97,103,783.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,917,662.00	26,205,772.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,917,662.00	4,244,614.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	21,961,158.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	70,898,011.66
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	70,898,011.66
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	45,833,250.09	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,833,250.09	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	700,325,888.34	700,325,888.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	700,325,888.34	700,325,888.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	700,325,888.34	700,325,888.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,798,525.00	561,798,524.03
210101	Үндсэн цалин	356,791,200.00	538,510,527.34
210102	Нэмэгдэл	166,084,625.00	22,371,370.69
210104	Урамшуулал	38,922,700.00	916,626.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,585,000.00	76,744,387.31
210201	Тэтгэврийн даатгал	53,893,100.00	71,145,487.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,673,000.00	1,399,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,538,300.00	1,119,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,134,600.00	280,000.00

210205	Эрүүл мэндийн даатгал	11,346,000.00	2,799,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,912,500.00	28,506,140.00
210301	Гэрэл, цахилгаан	4,212,500.00	4,116,740.00
210302	Түлш, халаалт	24,300,000.00	22,839,400.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	1,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,649,000.00	3,957,800.00
210401	Бичиг хэрэг	225,700.00	627,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,697,500.00	2,402,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	185,700.00	750,000.00
210404	Ном, хэвлэл	129,100.00	49,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	411,000.00	128,500.00
2105	Нормативт зардал	23,565,550.00	23,883,274.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,000.00	334,474.00
210502	Хоол, хүнс	22,141,950.00	22,141,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,287,600.00	1,406,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	281,600.00	281,600.00
210604	Урсгал засвар	281,600.00	281,600.00
2107	Томилот, зочны зардал	233,800.00	00.00
210702	Дотоод албан томилот	233,800.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	719,600.00	1,049,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	473,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5580313.34	4105163.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,580,313.34	4,105,163.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	700,325,888.34	700,325,888.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	671,131,788.34	671,131,788.34
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	671,131,788.34	671,131,788.34
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,194,100.00	29,194,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	29,194,100.00	29,194,100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51.00	51.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00
620004	Гэрээт ажилтан	05.00	05.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан / төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,500,000	27280025
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,500,000	27280025
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000	1074253

2104	Хангамж, бараа материалын зардал		226100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		226100
2105	Нормативт зардал		848153
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		848153
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	26205772
2132	Бусад урсгал шилжүүлэг		26205772
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		4244614
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		21961158
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,500,000	23035411
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,500,000	23035411
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000	23035411

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцооз 2022 оны 2 дугаар сарын 12-нээс 2021 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 17-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүүхдийн хөгжил төлөвшил сурлагын амжилт чанарыг сайжруулах, хүүхдийн урлах үйлийг дэмжих, багшийг мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүүхэд хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа төлөвлөн сургалттай зайн, танхимын хосолсон байдлаар явуулах зорилготой.

Тайлант онд 4-5 насны бэлтгэл бүлгийн 134 хүүхдээс танхимаар 76, зайн хэлбэрээр 56, ахлах бүлгийн 122 хүүхдээс танхимаар 46, зайн хэлбэрээр 76 хүүхэд хамрагдсан. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь 4 болж буурсан. БСШУССайдын 2020 оны 06.02-ны өдрийн а/80 дугаар тушаалын дагуу бүлэг бүрийн Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнгээр хүүхэд бүрт

шаардлагатай дэмжлэг туслалцааг олж харах, багшийн сургалтын агуулга, арга зүйн байдалд дүгнэлт хийх, эцэг хүүхдүүдэд хүүхдийн хөгжил төлөвшлийн талаарх бодит мэдээлэл өгөх шаардлагыг бодитой болгосон.

Тайланг хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2018 оноос хойш шинэчлэлт хийгдээгүй.

2021 онд аймгийн Засаг даргын тамгын газар болон Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээгүй. Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны санхүүгийн тайланд аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны батлагдсан төсвийн 771223,9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 15424,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12339,6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18643,5 мянган төгрөгөөр буюу 20,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө данс материаллаг дүнгээр өөрчлөгдсөн байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага данс үлдэгдэлгүй

Бараа материалын дансны үлдэгдэл 86954,2 мянган төгрөг болж 1138,4 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар өссөн байна. Энэ нь аж ахуйн материалын өссөнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 205144,8 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх тус цэцэрлэгийн барилгын их засварын ажлын тендерт Элбэг гүн ХХК шалгарч 200000,0 мянган төгрөгийн үнэ бүхий засварын ажлыг хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгасан, сумын орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжүүлэн цэцэрлэгийн гал тогоонд 2200,0 мянган төгрөгийн уур татагч бэлтгэн нийлүүлсэн, төсвийн хөрөнгөөр 2944,8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилга, ном зэргийг худалдан авч нийт 205144,8 мянган төгрөгөөр өссөн байна.

Мөн дээрхи үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн зардал 25474,7 мянган төгрөг болсон, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 95 тоот тогтоолоор 14962,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 96 тоот тогтоолоор 30194,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг данс бүртгэлээс хасаж холбогдох залруулга дансны бичилтүүдийг хийж тайланд тусгаснаар 179670,0 мянган төгрөгөөр цэвэр хөрөнгийн дүн өссөн байна.

Тайлант онд цалингийн тооцоолол программын тооцоололоос хамаарч зөрүүтэй тооцогдож цалин 4035,3, ХАОАТ-н 1937,1 мянган төгрөгөөр тус тус дутуу олгогдсоноос хамаарч 5972,4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Балансын хугацаанд үндсэн хөрөнгө өссөн, өр төлбөр нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор тайлангийн үеийн үр дүн 174826,0 мянган төгрөгөөр өссөж хуримтлагдсан үр дүн 176737,3 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 832954,9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 832954,9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг тодотгох замаар 771223,9 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 771223,9 мянган төгрөгийн төсөв баталснаас 742029,8 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 29194,1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/ санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 742029,8 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 29194,1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/ 771223,9 мянган төгрөгийн төсөв бүрдүүлснээс 70898,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 700325,6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 700325,6 мянган төгрөг буюу 90,8 хувьтай байгаа нь Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 5497,6 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 1460,6 мянган төгрөгөөр, хоол 63431,0 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт дансаар БСГ-аас Ковид-19 цар тахалын хүрээнд олгосон ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 1074,2 мянган төгрөг, БСГазраас хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажилласны нэмэгдэлд 21961,1 мянган төгрөгийг, НД-ын сангаас олгох тэтгэмжинд 4244,6 нийт 27280,0, мянган төгрөгийн орлого орж тус тусын зориулалтын дагуу зарцуулагджээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 109 мэдээллээс хугацаандаа 99 мэдээллийг хугацаандаа оруулж, 10 мэдээлэл хугацаа хожимдож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүүхдийн хоолны зардлыг нормоос хэтрүүлэн зарцуулсан, хоолны талон засвар ихтэй, хүнсний тооллого хийгээгүй, амархан муудах ногоо, мах, сүүний үлдэгдэл ихтэй, их хэмжээгээр нөөцөлсөн, Үндсэн хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, шинээр нэмэгдсэн хөрөнгө хүлээн авсан шийдвэргүй, бараа материалд хөрөнгө бүртгэлтэй хөрөнгө эмх цэгцгүй байгаа, Нүүрсний тооцоо хийж баталгаажуулаагүй, нормоос хэтрүүлэн нүүрс зарцуулж төсвийн үрэлгэн зардал гаргасан, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, ашиг тооцож төсөвт төвлөрүүлээгүй зэрэг зөрчил дутагдлыг арилгаж Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг хүргүүлжээ.

Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХОАТ суутгаагүй иргэдээс уг татварыг суутган төсөвт төвлөрүүлсэн, нүүрсний зарцуулалтын тооцоог сар бүр хянаж эд хариуцагчийн тооцоо бодсон, үндсэн хөрөнгө бараа материалын тооллогыг жилийн эцсээр байгууллагын даргын тушаалаар комисс томилон томилогдсон гишүүд тооллого хийж баримтжуулсан, хүнсний материалын нөөц өмнөх оноос 5,6 хувиар буурсан зэргээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан тухайгаа 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 46 тоот албан бичигээр аймгийн Аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар үр дүнгийн урамшууллын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хүнс, махны нөөцийн үлдэгдлийн зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэхээр тусгажээ.

Байгууллагын ажиллагсадын үр дүнгийн урамшуулал холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр олгож байна. Тухайлбал: Цэцэрлэгийн эрхлэгчийн үр дүнгийн урамшууллын шийлвэрийг аймгийн БС-н газрын дарга гаргаж байсан бол одоо сумын засаг дарга гаргадаг болсон байна.

Хүнс махны нөөцийн хэмжээ өмнөх оноос 5,6 хувиар буурчээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8445,3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8445,3 мянган төгрөгийн алдааг залруулж, Хүнсний нөөцийн хэмжээг бууруулах, зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байгаа алдааг засах 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар 8445,3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аудитаар хүнсний нөөцийн хэмжээг бууруулах, зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна.

Эрсдэл: Төсвийн үр ашиггүй зарцуулалт гарах үнэн зөв бодитой байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг дагаж мөрдөхийг зөвлөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын цэцэрлэг	5	8,445.3	4	8445.3	0	0	0	0	1	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Х.БОЛДБААТАР*
 АУДИТЫН МЕНЕЖЕР: *А.ЦЭЦЭГСҮРЭН*

ТАЙЛАНГ БИЧСЭН:
 АУДИТОР: *Ч. МӨНХЦООЗ*

